

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР БАНКНААС БУСАД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-4.1.8 болон 4.1.10-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд /цаашид “МҮЭ” гэх/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, заавраар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад зайнаас болон газар дээр нь хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэ журамд заасан хяналт шалгалтын удирдамжийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны дарга батална.

1.3. МҮЭ-ийн хяналт шалгалтын болон эрсдэлийн үнэлгээний хувийн хэргийг Хорооны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий газар, нэгж бүрдүүлж, хөтөлнө.

1.4. Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалт хийхэд энэ журмыг баримталж болно.

ХОЁР. ХЯНАЛТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ МҮЭ хэрхэн хэрэгжүүлж байгаад Хорооноос тавих хяналт шалгалт нь дараах төрөлтэй байна:

2.1.1. зайны хяналт шалгалт;

2.1.2. газар дээрх хяналт шалгалт.

2.2. Зайны хяналт шалгалт нь дараах хэлбэртэй байна:

2.2.1. байнгын хяналт шалгалт;

2.2.2. тусгайлсан хяналт шалгалт;

2.3. Газар дээрх хяналт шалгалтыг дараах хэлбэртэй байна.

2.3.1. төлөвлөгөөт хяналт шалгалт;

2.3.2. төлөвлөгөөт бус хяналт шалгалт;

2.4. Зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хянан шалгагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ. Газар дээрх хяналт шалгалтыг зөвхөн улсын байцаагчийн эрхтэй хянан шалгагч, улсын байцаагч дангаараа хэрэгжүүлэх буюу эсвэл ажлын хэсгийг удирдана.

2.5. Хянан шалгагч, улсын байцаагч нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, бусад хууль, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм болон энэ журмын хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хороо нь МҮЭ-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд эрсдэлийн үнэлгээг дараах төрлөөр хийж гүйцэтгэнэ.

3.1.1. салбарын эрсдэлийн үнэлгээ;

3.1.2. МҮЭ тус бүрийн эрсдэлийн үнэлгээ;

3.2. Салбарын эрсдэлийн үнэлгээнд тухайн салбарын эрсдэл, эмзэг байдал, анхаарах асуудлыг хамруулсан байна.

3.3. Салбарын эрсдэлийн үнэлгээг 2 жил тутам үнэлж, үр дүнг Хорооны удирдлагад танилцуулна.

3.4.МҮЭ тус бүрийн эрсдэлийн үнэлгээнд харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүргэх арга, хэлбэр, газар зүйн байршлын эрсдэлт нөхцөлийг хамруулсан байна.

3.5.МҮЭ тус бүрийн эрсдэлийг үнэлж, эрсдэлийн түвшинг дараах байдлаар ангилна:

- 3.5.1.эрсдэл багатай;
- 3.5.2.дунджаас доогуур эрсдэлтэй;
- 3.5.3.дунд эрсдэлтэй;
- 3.5.4.дунджаас дээгүүр эрсдэлтэй;
- 3.5.5.эрсдэл өндөртэй.

3.6.Энэ журмын 3.1.2-т заасан эрсдэлийн үнэлгээг МҮЭ-ээс хагас жил тутам цахимаар авч, хувийн хэрэг бүрдүүлэн ажиллана.

3.7.Энэ журмын 3.1-т заасан эрсдэлийг үнэлэх аргачлал, матриц, тайлан мэдээний загварыг Хорооны дарга батална.

3.8.Энэ журмын 3.1-т заасан эрсдэлийн үнэлгээ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэн баталсан дотоод хяналтын хөтөлбөр зэрэгт үндэслэн зайны болон газар дээрх хяналт шалгалтын давтамж, цар хүрээг тодорхойлно.

ДӨРӨВ. ЗАЙНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

4.1.Хороо нь МҮЭ-ийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад байнга хянаж үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах замаар учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор зайны хяналт шалгалтыг хийнэ.

4.2 Зайны хяналт шалгалтыг дараах үндэслэл, арга хэлбэрээр хэрэгжүүлнэ

- 4.2.1.эрсдэлийн үнэлгээ, асуулгаар;
- 4.2.2.тусгайлсан программ хангамжаар;
- 4.2.3.МҮЭ болон холбогдох бусад этгээдээс ирүүлсэн тайлан, мэдээлэл;
- 4.2.4.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад арга, хэлбэр.

4.3.Байнгын хяналт шалгалтыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 4.3.1.эрсдэлийн үнэлгээ хийх;
- 4.3.2.МҮЭ-ийн эрсдэлийн оноог тооцоолж, эрсдэлийн үнэлгээний хувийн хэргийг шинэчлэх;
- 4.3.3.МҮЭ-ээс ирүүлсэн тайлан мэдээнд үндэслэн нэмэлт материал, баримт бичиг шаардах;
- 4.3.4.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн холбогдох зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахыг даалгах.
- 4.3.5.зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн үүрэг даалгаврыг шалгах үзлэг.

4.4.Хороо нь дараах үндэслэлээр МҮЭ-д тусгайлсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж болно.

- 4.4.1.байнгын хяналт шалгалтын үнэлгээгээр эрсдэлтэй, өндөр эрсдэлтэй дүгнэгдсэн;
- 4.4.2.Хорооны хяналт шалгалт хариуцсан нэгжийн санал;
- 4.4.3.олон улсын байгууллагаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан үнэлгээний тайланд МҮЭ-ийг эрсдэлтэй, өндөр эрсдэлтэй гэж дурдсан;
- 4.4.4.эрх бүхий байгууллагаас бичгээр ирүүлсэн санал, дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл, анхааруулга, тодорхойлолт;

4.4.5.иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээлэл.

4.5.МҮЭ нь зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах тайлан мэдээг Хороонд цахим хэлбэрээр 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор болон дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ:

4.5.1.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, тус хэрэгжилтийг хангах эрх бүхий этгээдийн үйл ажиллагааны тайлан, мэдээ;

4.5.2.энэ журмын 3.7-д заасан тайлан, мэдээ.

4.6.Зайны хяналт шалгалтад шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Хороо МҮЭ-ийн талаарх мэдээ, мэдээллийг авах хүсэлтийг хуульд заасан журмын дагуу дотоодын болон гадаадын бусад эрх бүхий байгууллагуудад тавьж болно.

4.7.Зайны хяналт шалгалтын үр дүнг тухай бүр Хорооны удирдлагад, шаардлагатай тохиолдолд Хорооны хуралдаанд танилцуулна.

ТАВ. ЗАЙНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ

5.1.Хяналт шалгалт хариуцсан нэгжээс зайны хяналт шалгалтын үр дүн, МҮЭ-ээс ирүүлсэн тайлан, мэдээний чанар, хугацаа, өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэрэгт үндэслэн дүгнэлт гаргана.

5.2.Зайны хяналт шалгалтын дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

5.2.1.энэ журмын 4.5.1, 4.5.2-т заасан тайлан, мэдээг МҮЭ ирүүлсэн эсэх;

5.2.2.МҮЭ-ийн эрсдэлд хийсэн үнэлгээ;

5.2.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, журмыг баталж, дагаж мөрдөж буй эсэх;

5.2.4.МҮЭ-ийн үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилсон эсэх;

5.2.5.хариуцсан нэгжийн санал.

5.3.Зайны хяналт шалгалтын дүгнэлтээс МҮЭ-д нэмэлт бүртгэл, зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, үйл ажиллагаанд аливаа өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн болон татгалзсан санал гарна.

5.4.Энэ журмын 5.3-т заасан саналыг дүгнэлт авсан нэгж Хорооны хуралдааны танилцуулгад тусгана.

ЗУРГАА. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

6.1.Хороо нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх холбогдох хууль, журмыг МҮЭ хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж байгаад нарийвчилсан үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор газар дээрх хяналт шалгалтыг хийнэ.

6.2.Газар дээрх хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хийнэ:

6.2.1.МҮЭ нь энэ журмын 3.4.3, 3.4.4, 3.4.5-т зааснаар үнэлэгдсэн;

6.2.2.энэ журмын 4.4-т заасан;

6.2.3.зайны хяналт шалгалтын үр дүнд үндэслэн.

6.3.Газар дээрх хяналт шалгалтыг хийхийн өмнө тухайн шалгалтын хамрах хүрээ, үнэлэх үзүүлэлтийг харгалзан дараах баримт, мэдээлэлтэй танилцана.

6.3.1.энэ журмын 6.2-т заасан үндэслэл, тэдгээртэй холбоотой материал;

6.3.2.өмнө хийгдсэн хяналт шалгалтын материал, тайлан;

6.3.3.өмнө хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлт;

6.3.4.Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр МҮЭ-ийн талаар гаргасан лавлагаа, дүгнэлт;

6.3.5.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр МҮЭ-ийн боловсруулсан дотоод бодлого, дүрэм, журам, тэдгээрт орсон өөрчлөлт;

6.3.6.бусад.

6.4.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Хорооноос баталсан газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу хийнэ.

6.5.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Хорооны даргын баталсан хяналт шалгалтын удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

6.6.Газар дээрх хяналт шалгалтын төлөвлөсөн хугацааг хариуцсан нэгжийн дарга нэг удаа сунгаж болно.

6.7.Газар дээрх хянан шалгалтын удирдамжид нэр нь дурдагдаагүй хянан шалгагч, улсын байцаагч, эрх бүхий албан тушаалтан газар дээрх хяналт шалгалтад оролцохыг хориглоно.

ДОЛОО. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАН

7.1.Хянан шалгагч, улсын байцаагч газар дээрх хяналт шалгалтад хамрагдаж байгаа МҮЭ-д хадгалагдаж байгаа дор дурдсан бичиг баримт, мэдээллийг гаргуулан авна:

7.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, үйл ажиллагаа явуулах бүртгэл, зөвшөөрөл, хууль ёсоор итгэмжлэн төлөөлөх эрх олгосон баримт бичиг;

7.1.2.хувьцаа эзэмшигчдийн бүтэц, удирдлага зохион байгуулалтад орсон өөрчлөлт, хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл, бусад холбогдох мэдээлэл;

7.1.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй хэрэгжилт хариуцсан ажилтан томилсон шийдвэр;

7.1.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомж, дүрэм журмын дагуу МҮЭ батлан хэрэглэж буй дотоод бодлого, журмууд;

7.1.5.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр өмнө хийсэн хяналт шалгалтын ажлын тайлан, холбогдох материалууд;

7.1.6.өмнөх хяналт шалгалтаас өгсөн зөвлөмж/арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

7.1.7.МҮЭ-ийн гүйцэтгэсэн гүйлгээнүүдийг /удирдамжид тогтоосон цаг хугацаа/ тодруулан харуулсан санхүүгийн тайлангууд болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримт бичиг;

7.1.8.харилцагчийг таньж мэдэх болон Харилцагчийн мэдээллийг нягтлан шалгах үйл ажиллагааны баримтжуулалт;

7.1.9.МҮЭ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл;

7.1.10.харилцагч/гуравдагч талуудаас МҮЭ-д ирүүлсэн гомдол;

7.1.11.Санхүүгийн мэдээллийн албанд илгээсэн тайлангуудын талаарх мэдээлэл;

7.1.12.сэжигтэй гүйлгээ илрүүлж, мэдээлэх үйл ажиллагаа;

7.1.13.үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа болон Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоол, НҮБ-ын аюулгүйн зөвлөлөөс гаргасан террорист этгээдүүдийн нэрсийн жагсаалтыг ашиглаж байгаа байдал;

7.1.14.терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоол болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан террорист этгээдийн нэрсийн жагсаалтыг ашиглаж байгаа байдал;

7.1.15.шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын явцад тулгарсан аливаа асуудлыг тодруулах зорилгоор МҮЭ-ийн эрх бүхий албан тушаалтнаас нэмэлт мэдээлэл;

7.1.16.хууль тогтоомжид заасан бусад баримт бичиг.

7.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр МҮЭ-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтын нэгдсэн үнэлгээ, дүн өгөхдөө шалгалтын ажлын хэсэг дараах зарчмыг баримтална:

7.2.1.шалгалтын ажлын хэсгийн гишүүд МҮЭ-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын бүрдэл, шалгуур тус бүрээр дараах үнэлгээг өгнө:

7.2.1.1.хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй;

7.2.1.2. хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй

7.2.1.3.хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай;

7.2.1.4.хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан.

7.2.2.шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь бүрдэл тус бүрд өгсөн үнэлгээг харгалзан нэгдсэн үнэлгээ өгөх ба шалгалтын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж, шалгалтын хэсгийн ахлагч улсын байцаагчийн тэмдэг дарж нэгдсэн үнэлгээг баталгаажуулна.

7.4.Газар дээрх хяналт шалгалтыг хийж дууссаны дараа улсын байцаагч шалгалтаар илэрсэн нөхцөл байдал, алдаа дутагдал, нотлох баримт, дүгнэлт зэргийг багтаасан дэлгэрэнгүй тайлан боловсруулж гаргана. Тайланд дараах мэдээллүүдийг тусгана:

7.4.1.хяналт шалгалт явуулах үндэслэл, хамрах хүрээ, хяналт шалгалт хийсэн хугацаа;

7.4.2.хяналт шалгалтад хамрагдсан этгээд, түүний хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч, хяналт шалгалтыг гүйцэтгэсэн улсын байцаагчдын нэрс;

7.4.3.хяналт шалгалтад хамрагдсан МҮЭ-ийн үйл ажиллагаанд холбогдуулан цуглуулсан мэдээлэлд хийсэн дүгнэлт;

7.4.4.шалгалтын явцад илэрсэн бусад алдаа дутагдал;

7.4.5.илэрсэн алдаа, дутагдал, тэдгээрийн нотлох баримт ;

7.4.6.нэгдсэн үнэлгээ, шалгалтын дүн;

7.4.7.зөвлөмж болон үүрэг даалгавар;

7.4.8.бусад.

7.5.Хяналт шалгалт дууссанаас хойш хяналт шалгалтын удирдамжид заасан хугацаанд багтааж тайланг Хорооны удирдлагад танилцуулна.

7.6 Шалгалтын дүнг МҮЭ хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шалгалтын тайлантай танилцсанаас хойш ажлын 14 хоногийн дотор Хорооны даргад бичгээр гомдол гаргаж болно.

7.7. Шалгалтын дүгнэлт, холбогдох материалыг тухайн МҮЭ-ийн хувийн хэрэгт хавсаргана.

7.8.Тодорхой мэдээллийн дагуу хийгдсэн төлөвлөгөөт бус шалгалтын дараа нэгдсэн үнэлгээ хийгдэхгүй. Зөвхөн мэдээлэлтэй холбоотой хянан шалгагч, улсын байцаагчийн дүгнэлт гарч түүний дагуу шаардлагатай арга хэмжээг авна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1.Зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүнд МҮЭ-ийн бүртгэл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах, эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох, шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг нээх, эсхүл гэмт хэргийн шинжтэй тохиолдолд харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.